



**ӨРГӨН НЭВТРҮҮЛГИЙН ҮЙЛЧИЛГЭЭ  
ЭРХЛЭГЧДИЙН ШУДАРГА ӨРСӨЛДӨХ  
НӨХЦӨЛИЙГ БҮРДҮҮЛЭХ ЧИГЛЭЛЭЭР  
АВЧ ХЭРЭГЖҮҮЛСЭН АРГА  
ХЭМЖЭЭНИЙ НӨХЦӨЛ БАЙДАЛД  
ХИЙСЭН ҮНЭЛГЭЭ, ДҮГНЭЛТ**

**20  
25**

## АГУУЛГА

Өргөн нэвтрүүлгийн үйлчилгээ эрхлэгчдийн шударга өрсөлдөх нөхцөлийг бүрдүүлэх чиглэлээр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний нөхцөл байдалд хийсэн үнэлгээ, дүгнэлт .....	2
<b>I. ӨРГӨН НЭВТРҮҮЛГИЙН ХУУЛЬ ЭРХ ЗҮЙН ОРЧИН, ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙН НӨХЦӨЛ, ШААРДЛАГЫН ХЭРЭГЖИЛТЭД ХИЙСЭН ҮНЭЛЭЛТ, ДҮГНЭЛТ, ХЭРЭГЖИЛТИЙГ ХАНГУУЛАХ ЧИГЛЭЛЭЭР АВЧ ХЭРЭГЖҮҮЛСЭН АРГА ХЭМЖЭЭ .....</b>	<b>3</b>
Нэг. Эрх зүйн орчныг боловсронгуй болгох чиглэлээр .....	3
Хоёр. Тусгай зөвшөөрлийн нөхцөл, шаардлагын хэрэгжилтэд хийсэн үнэлэлт, дүгнэлт .....	3
Гурав. Зохицуулах хорооноос хийж гүйцэтгэсэн хяналт, шалгалтын талаар .....	4
Дөрөв. Зохицуулах хорооноос хийж байгаа хяналт, мониторингийн талаар .....	4
Тав. Хүүхдийг зохисгүй агуулгаас хамгаалах чиглэлээр авч хэрэгжүүлсэн ажил .....	5
<b>II. ТАЙЛАНТ ХУГАЦААНД ХУУЛЬД ЗААСАН ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ ОЛГОСОН, СУНГАСАН, ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛСАН, ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙГ ТҮДГЭЛЗҮҮЛСЭН, СЭРГЭЭСЭН, ХҮЧИНГҮЙ БОЛГОСОН ТОО, МЭДЭЭ .....</b>	<b>6</b>
Нэг. Нээлттэй сонгон шалгаруулалтаар олгох тусгай зөвшөөрлийн тоо тогтоосон байдал, сонгон шалгаруулалтын дүн .....	7
Хоёр. Төлбөртэй телевизийн төрөлд тусгай зөвшөөрөл олгох хүсэлт шийдвэрлэсэн байдал .....	7
Гурав. Тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлсэн арга хэмжээний талаар .....	7
Дөрөв. Тусгай зөвшөөрлийн хугацаа сунгасан байдал .....	8
Тав. Тусгай зөвшөөрлийг хүчингүй болгосон байдал .....	8
Зургаа. Тусгай зөвшөөрөлд нэмэлт, өөрчлөлт оруулсан байдал .....	9
<b>III. ӨРГӨН НЭВТРҮҮЛГИЙН ҮЙЛЧИЛГЭЭ ЭРХЛЭХ ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛТЭЙ ЭТГЭЭДИЙН ЭЗЭМШЛИЙН ТАЛААРХ МЭДЭЭЛЛИЙГ ИЛ ТОД БАЙЛГАХ ЗОХИЦУУЛАЛТ, ХЭРЭГЖИЛТИЙН НӨХЦӨЛ БАЙДАЛ, ҮНЭЛЭЛТ, ДҮГНЭЛТ .....</b>	<b>9</b>
<b>IV. ӨРГӨН НЭВТРҮҮЛГИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАХ ЗЭЭЛ, ӨРСӨЛДӨӨНИЙ НӨХЦӨЛ БАЙДЛЫН ТАЛААРХ СУДАЛГАА, ҮНЭЛЭЛТ, ДҮГНЭЛТ .....</b>	<b>10</b>
Нэг. Монгол Улсын хүн ам, өрхийн тоо, нягтралын байдал .....	10
Хоёр. Өргөн нэвтрүүлгийн үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөлтэй этгээдийн тоо .....	11
Гурав. Өргөн нэвтрүүлгийн үйлчилгээний зах зээлийн багтаамж, хэмжээ, хэрэглэгчийн тоо, өрсөлдөөний нөхцөл байдал .....	11
Дөрөв. Эрэлт, хэрэгцээ .....	18
<b>V. ХОРООНООС 2024 ОНД НЭЭЛТТЭЙ СОНГОН ШАЛГАРУУЛАЛТААР ОЛГОХ ӨРГӨН НЭВТРҮҮЛГИЙН ҮЙЛЧИЛГЭЭ ЭРХЛЭХ ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙН ТОО ТОГТООХ ЭСЭХЭД БАРИМТАЛСАН ЗАРЧИМ, ХАРГАЛЗАН ҮЗСЭН ҮЗҮҮЛЭЛТ, ШИЙДВЭР .....</b>	<b>19</b>
Нэг. Өргөн нэвтрүүлгийн үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрлийн тоо тогтоох эсэхэд баримталсан зарчим, харгалзан үзсэн үзүүлэлтүүд .....	19
Хоёр. Тус Хорооноос 2025 онд сонгон шалгаруулалтаар олгох өргөн нэвтрүүлгийн үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрлийн тоо тогтоох эсэх тухай .....	21



## **Өргөн нэвтрүүлгийн үйлчилгээ эрхлэгчдийн шударга өрсөлдөх нөхцөлийг бүрдүүлэх чиглэлээр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний нөхцөл байдалд хийсэн үнэлгээ, дүгнэлт**

Харилцаа холбооны зохицуулах хороо нь Өргөн нэвтрүүлгийн тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.1.3 дахь хэсэгт заасан эрх, үүргийн дагуу өргөн нэвтрүүлгийн үйлчилгээ эрхлэгчдийн зах зээлд шударга өрсөлдөх нөхцөлийг бүрдүүлэх, жил бүр үнэлэлт, дүгнэлт гаргаж ажиллах бүрэн эрхээ хэрэгжүүлэн ажиллаж байна.

ХХЗХ нь Өргөн нэвтрүүлгийн тухай хууль (ӨНТХ)-иар олгогдсон бүрэн эрх, чиг үүрэг, өргөн нэвтрүүлгийн салбарт төрөөс баримтлах бодлого, бусад холбогдох хууль, тогтоомжуудын хүрээнд зохицуулалт хийж, зах зээлд үр ашигтай, шударга өрсөлдөх нөхцөлийг бүрдүүлэх зорилгыг хангуулж ажилладаг.

ӨНТХ-иар өргөн нэвтрүүлгийн үйлчилгээ эрхлэх эрх зүйн үндсийг тодорхойлж, зах зээлийн шударга өрсөлдөөний таатай орчныг бүрдүүлэх, үндэсний болон нийтийн ашиг сонирхолд нийцсэн өргөн нэвтрүүлгийн үйлчилгээ эрхлэхтэй холбогдсон харилцааг зохицуулахаар хуульчилсан. Иймээс өргөн нэвтрүүлгийн бодлого, зохицуулалтын болон салбарын үйл ажиллагаанд зайлшгүй баримтлах зарчмуудыг тус хуулийн 5 дугаар зүйлээр заасан ба 5.1.9-д "... зах зээлийн өрсөлдөөний таатай орчныг бүрдүүлж, өргөн нэвтрүүлгийн салбарын хөгжлийг дэмжин хөгжүүлэх" зарчмыг баримтлахаар хуульчилсан байдаг.

ХХЗХ нь ӨНТХ-ийн 30 дугаар зүйлийн 30.1.10-т заасныг үндэслэн хуульд заасан тусгай зөвшөөрөл олгох, сунгах, тусгай зөвшөөрөлд нэмэлт, өөрчлөлт оруулах, тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлэх, сэргээх, хүчингүй болгох, тусгай зөвшөөрлийн нөхцөл, шаардлага болон холбогдох журмыг батлах, гэрээ байгуулах, биелэлтэд хяналт тавих, хууль тогтоомж, дүрэм журам, нөхцөл, шаардлагын хэрэгжилтийг хангуулах замаар өргөн нэвтрүүлгийн зах зээлд шударга өрсөлдөх нөхцөлийг бүрдүүлэх зорилтыг хэрэгжүүлэхээр ажиллаж байна.

Түүнчлэн өргөн нэвтрүүлгийн үйлчилгээтэй холбоотой онцлог зохицуулалтыг хэрэгжүүлж, өргөн нэвтрүүлгийг хараат бус, нээлттэй, ёс зүйтэй байлгах, шударга өрсөлдөх нөхцөлийг бий болгох, иргэдийн мэдэх эрхийг хангах зорилгоор ӨНТХ-ийн 19 дүгээр зүйлийн 19.5-д зааснаар өргөн нэвтрүүлгийн үйлчилгээ эрхлэгчдийн эзэмшлийн талаарх мэдээллийг жил бүр олон нийтэд ил тод мэдээлж байна. ХХЗХ нь хуульд заасан дээр чиг үүрэг, зорилгын хүрээнд бүрэн эрхийнхээ дагуу хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангуулахтай холбоотой үйл ажиллагааг тасралтгүй хэрэгжүүлж, холбогдох арга хэмжээг тогтмол авч ажиллаж байгаа бөгөөд зах зээл, хүн ам, эрэлт хэрэгцээ, эзэмшил, нөхцөл байдлын судалгаанд үндэслэн өрсөлдөөний нөхцөл байдалд үнэлэлт, дүгнэлт өгч, тусгай зөвшөөрлийн тоо тогтоох, олгох эсэх шийдвэрийг судалгаа, үнэлэлт, дүгнэлтэд үндэслэн 2021 оноос жил бүр гаргаж байна.

Тус Хорооноос өргөн нэвтрүүлгийн үйлчилгээ эрхлэгчдийн шударга өрсөлдөх нөхцөл байдалд үнэлэлт, дүгнэлт гаргахад дараах үндсэн чиглэлийг авч үздэг бөгөөд үүний хүрээнд хийсэн судалгаа, мэдээлэлд үндэслэн үнэлэлт, дүгнэлт гаргадаг болно. Үүнд:

- I. Өргөн нэвтрүүлгийн хууль эрх зүйн орчин, тусгай зөвшөөрлийн нөхцөл, шаардлагын хэрэгжилтэд хийсэн үнэлэлт, дүгнэлт, хэрэгжилтийг хангуулах чиглэлээр авч хэрэгжүүлсэн арга хэмжээ;



- II. Тайлант хугацаанд тусгай зөвшөөрөл олгосон, сунгасан, тусгай зөвшөөрөлд нэмэлт, өөрчлөлт оруулсан, тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлсэн, сэргээсэн, хүчингүй болгосон тоо, мэдээ;
- III. Өргөн нэвтрүүлгийн үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөлтэй этгээдийн эзэмшлийн талаарх мэдээллийг ил тод байлгах зохицуулалт, хэрэгжилтийн нөхцөл байдал, үнэлэлт, дүгнэлт;
- IV. Өргөн нэвтрүүлгийн үйлчилгээний зах зээл, өрсөлдөөний нөхцөл байдлын талаарх судалгаа, үнэлэлт, дүгнэлт;
- V. Тус хорооноос 2025 онд нээлттэй сонгон шалгаруулалтаар олгох өргөн нэвтрүүлгийн үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрлийн тоо тогтоох эсэхэд баримталсан зарчим, харгалзан үзсэн үзүүлэлт, шийдвэр.

Дээрх чиглэлээр тус Хорооноос хийж хэрэгжүүлсэн арга хэмжээ, мэдээлэл, судалгаа, үнэлгээ дүгнэлтийг дэлгэрэнгүй авч үзье.

## **I. ӨРГӨН НЭВТРҮҮЛГИЙН ХУУЛЬ ЭРХ ЗҮЙН ОРЧИН, ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙН НӨХЦӨЛ, ШААРДЛАГЫН ХЭРЭГЖИЛТЭД ХИЙСЭН ҮНЭЛЭЛТ, ДҮГНЭЛТ, ХЭРЭГЖИЛТИЙГ ХАНГУУЛАХ ЧИГЛЭЛЭЭР АВЧ ХЭРЭГЖҮҮЛСЭН АРГА ХЭМЖЭЭ**

### **Нэг. Эрх зүйн орчныг боловсронгуй болгох чиглэлээр**

“Телевизийн үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрлийн нөхцөл, шаардлага”-д Хорооны 2024 оны 02 дугаар сарын 22-ны 33 дугаар тогтоолоор нэмэлт, өөрчлөлт оруулан, захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн санд холбогдох хөдөлгөөнийг хийлгэсэн. Уг нэмэлт, өөрчлөлтөөр орон нутгийн телевизүүд хөтөлбөрөө олон суваг дамжуулах үйлчилгээ эрхлэгчдийн сүлжээгээр дамжуулан зөвхөн тусгай зөвшөөрөлд заасан буюу тухайн аймаг, орон нутагтаа хүргэх боломжтой харин бусад аймаг, сумдад дахин дамжуулах боломжгүй, хязгаарлагдмал зохицуулалт үйлчилж байсныг өөрчилсөн. Өөрөөр хэлбэл орон нутгийн телевизийн үйлчилгээ эрхлэгч нь хүсэлт гарган хажуу, зэргэлдээ аймагт хөтөлбөрөө дамжуулах боломжийг нээснээр орон нутгийн телевизүүдийн хөгжилд ихээхэн нэмэр болохос гадна ард иргэд ч хөрш зэргэлдээ аймгийнхаа мэдээ, мэдээллийг авах боломжтой болсон.

### **Хоёр. Тусгай зөвшөөрлийн нөхцөл, шаардлагын хэрэгжилт, тусгай зөвшөөрлийн гэрээний үүргийн хэрэгжилтэд хийсэн үнэлэлт, дүгнэлт**

2023 онд Радио болон телевизийн хөтөлбөрт тавигдах шаардлага, Радио, телевизээр нэвтрүүлэх зар сурталчилгааны зохицуулалтын журам, Радио, телевизийн үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрлийн нөхцөл, шаардлага гэсэн 6 баримт бичигт Хорооны даргын 2023 оны А/182 тоот тушаалаар батлагдсан “Зохицуулалтын баримт бичигт үнэлгээ хийх удирдамж”-ийн дагуу үнэлэлт, дүгнэлт хийж Даргын зөвлөлийн хуралд танилцуулсан бол 2024 онд Олон суваг дамжуулах үйлчилгээнд хамаарах “Олон суваг дамжуулах үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрлийн нөхцөл, шаардлага”, “Радио, телевизийн газрын сүлжээний үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрлийн нөхцөл, шаардлага” зэрэг зохицуулалтын баримт бичгүүдэд холбогдох аргачлалын дагуу үнэлэлт, дүгнэлт хийж 2024 оны 10 дугаар сарын ээлжит Даргын зөвлөлийн хуралд танилцууллаа. 2025 оны 3 дугаар сарын 13-ни өдрийн Даргын зөвлөлийн хуралд Телевизийн хөтөлбөрт тавигдах шаардлага,

Телевизээр нэвтрүүлэх зар сурталчилгааны зохицуулалтын журмын хэрэгжилтийн байдлыг орон нутгийн телевизийн хөтөлбөрийн мониторингид үндэслэн гаргаж танилцуулсан.

Хорооны даргын 2023 оны 12 дугаар сарын 12-ны өдрийн А/352 тоот тушаалаар батлагдсан “Тусгай зөвшөөрлийн гэрээний үүргийн хэрэгжилт дүгнэх ерөнхий аргачлал” батлагдсан. Уг аргачлалаар радио, телевиз, олон суваг дамжуулах үйлчилгээ болон радио, телевизийн газрын сүлжээний үйлчилгээний гэрээний үүргийг дүгнэх маягтыг боловсруулан батлан гаргасан.

### **Гурав. Зохицуулах хорооноос хийж гүйцэтгэсэн хяналтын талаар**

Зохицуулах хороо нь ӨНТХ, Харилцаа холбооны тухай хууль, Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн хүрээнд үйлчилгээ эрхлэгчдийн үйл ажиллагаа, нөхцөл шаардлага, гэрээний үүргийн хэрэгжилтийн байдалд төлөвлөгөөт болон төлөвлөгөөт бус хяналт, шалгалтыг хийж хуульд заасан холбогдох арга хэмжээг авч, зөвлөгөө мэдээлэл өгч ажилладаг.

Хорооны даргын 2024 оны 10 дугаар сарын 14-ний А/283 тоот тушаал, удирдамжийн хүрээнд Орхон аймагт үйл ажиллагаа явуулдаг олон суваг дамжуулах үйл ажиллагаа эрхлэгч (Агаарын суваг ХХК, Дархан ширхэнцэг ХХК), өргөн нэвтрүүлгийн телевизийн үйл ажиллагаа эрхлэгч Бунадо ХХК-ийн Тэнгэр ТВ, Ишилан ХХК-ийн EBS TV) гэсэн нийт 4 үйлчилгээ эрхлэгчийн үйл ажиллагаанд хяналт, шалгалт хийсэн. Эдгээр үйлчилгээ эрхлэгчдэд холбогдох хууль, тогтоомж, нөхцөл, шаардлагын хэрэгжилтийг хангаж ажиллах талаар албан бичгээр 2024 оны 11 дүгээр сарын 07-ны өдрийг хүртэлх хугацаатай үүрэг даалгавар өгч хэрэгжилтийг хангуулахаар ажиллаж байна.

Мөн Хорооны даргын 2024 оны 12 дугаар сарын 03-ны А/330 тоот тушаал, удирдамжийн хүрээнд Төв аймгийн 1 олон суваг дамжуулах үйлчилгээ эрхлэгч (Би Ти Жи ХХК), 1 өргөн нэвтрүүлгийн телевизийн үйлчилгээ эрхлэгчийн (Очир-Арвай ХХК-ийн Төв ТВ) үйл ажиллагаа, гэрээний үүргийн биелэлтэд үзлэг, хяналт хийж эдгээр үйлчилгээ эрхлэгчдэд зөвлөмж хүргүүлж ажилласан.

Улаанбаатар хотын өргөн нэвтрүүлгийн 18 телевиз, 14 арилжааны телевиз, 2 радиогийн үйлчилгээ эрхлэгчийн үйл ажиллагаанд хийх хяналтыг Хорооны даргын 2025 оны 03 дугаар сарын 14-ний өдрийн А/56 тоот тушаал, удирдамжийн дагуу хийж гүйцэтгэсэн. Хяналтын үр дүн, цаашид авах арга хэмжээний талаарх нэгдсэн дүгнэлтийг 2025 оны 5 дугаар сарын 21-ний өдрийн Даргын зөвлөлийн хуралд танилцуулж, тайлагнасан. Эдгээр 34 үйлчилгээ эрхлэгчдээс холбогдох хууль, тогтоомж, нөхцөл, шаардлагын хэрэгжилтийг хангаж ажиллах талаар 22 үйлчилгээ эрхлэгчдэд хугацаатай үүрэг даалгавар, 9 үйлчилгээ эрхлэгчдэд зөвлөмж хүргүүлж, хэрэгжилтийг хангуулахаар ажиллаж байна.

### **Дөрөв. Зохицуулах хорооноос хийж байгаа хяналт, мониторингийн талаар**

Өргөн нэвтрүүлгийн үйлчилгээ эрхлэгчдээс үйлчилгээний тасралтгүй ажиллагааны тайланг (ТАТ) тогтмол хүлээн авч, үйлчилгээний хэвийн тасралтгүй ажиллагааг хангуулах чиглэлээр телевизийн үйлчилгээ эрхлэгчдийн эфирийн ТАТ тайланг тус хорооноос хийдэг байнгын хяналт, мониторингийн хүрээнд болон олон суваг дамжуулах үйлчилгээ эрхлэгчид, телевизийн үйлчилгээ эрхлэгчдээс гэсэн 3 талаас хүлээн авч нэгтгэн, анализ хийж байгууллагын цахим хуудсанд байршуулан ажиллаж байна. (<https://www.crc.gov.mn/list/rq-n-nevtr-leg/mn?show=254>). Үйлчилгээ нь тасарсан үйлчилгээ эрхлэгчдээс эфир тасарсан шалтгааныг тодруулж, хариу тайлбар аван, анхааруулга хүргүүлэн ажиллаж байна.

ХХЗХ нь ӨНТХ-ийн 30 дугаар зүйлийн 30.1.8-д заасан эрх, чиг үүргийн хүрээнд “Телевизийн хөтөлбөрт тавигдах шаардлага”, “Телевизээр нэвтрүүлэх зар сурталчилгааны зохицуулалтын



журам”, “Радиоогийн хөтөлбөрт тавигдах шаардлага”, “Радиоогоор нэвтрүүлэх зар сурталчилгааны зохицуулалтын журам”-ын хэрэгжилтэд байнгын хяналт, мониторинг хийж байна.

- Телевизийн хөтөлбөрт хийдэг байнгын хяналт, мониторингийн хүрээнд:
  - Улаанбаатар хотод тусгай зөвшөөрөлтэй үйл ажиллагаа явуулж байгаа телевизүүд (үүнд: Монголын үндэсний олон нийтийн 5 телевиз, өргөн нэвтрүүлгийн 18 телевиз, арилжааны 48 телевиз) мониторингид хамрагдаж байна.
  - Орон нутагт тусгай зөвшөөрөлтэй нийт 45 телевизийн хөтөлбөрт түүврийн аргаар буюу сард 15 телевизийн хөтөлбөрт хяналт, мониторинг хийж байна.
- Радиоогийн хөтөлбөрт хийдэг байнгын хяналт, мониторингийн хүрээнд:
  - Улаанбаатар хотод үйл ажиллагаа явуулах тусгай зөвшөөрөлтэй радиоогийн (Монголын үндэсний олон нийтийн 4 радио, арилжааны 31 радио) хөтөлбөрт түүврийн аргаар буюу сар бүр 10 радиоогийн хөтөлбөрт хяналт, мониторинг хийж байна.

ХХЗХ нь радио, телевизүүдийн хөтөлбөрт хийсэн хяналт, мониторингийн тайланг үйлчилгээ эрхлэгчдэд тогтмол хүргүүлэх, холбогдох арга хэмжээ авах, хяналт, мониторингийн тайлан, мэдээг олон нийтэд ил тод мэдээлэн ажиллаж байна. Телевизийн хөтөлбөрийн хяналт, мониторингийн тайлан, мэдээллийн дэлгэрэнгүйг <https://www.crc.gov.mn/list/rg-n-nevtr-leg/mn?show=27> хуудсаас, радиоогийн хөтөлбөрийн хяналт, мониторингийн дүн, мэдээллийн дэлгэрэнгүйг <https://www.crc.gov.mn/list/rg-n-nevtr-leg/mn?show=251> хуудсаас сар, улирлаар дэлгэрэнгүй үзэх боломжтой.

Түүнчлэн радио, телевизүүдийн 2024 оны хөтөлбөрийн мониторингийн бүтэн жилийн тайлан, мэдээг аналитик дүгнэлттэйгээр энэ жил анх удаа цахим товхимол байдлаар бэлтгэн Хорооны цахим хуудсанд нээлттэй байршуулахаар бэлтгэж байна.

#### **Тав. Хүүхдийг зохисгүй агуулгаас хамгаалах чиглэлээр авч хэрэгжүүлсэн ажил**

Хүүхдийг зохисгүй агуулгаас хамгаалахад чиглэсэн радио, телевизийн хөтөлбөрийн дүрмийн хэрэгжилтэд хяналт тавих Орон тооны бус зөвлөлийн хурлыг холбогдох журмын дагуу тухай бүр зохион байгуулан ажиллаж байна.

Тайлант хугацаанд иргэдээс радио, телевизээр хүүхдэд зохисгүй агуулга, хараалын үг, хэллэг зэргийг гаргаж байгаа талаарх 5 гомдол ирснийг хүлээн авч, гомдлын дагуу тухайн радио, телевизийн үйлчилгээ эрхлэгчидтэй холбогдож хяналт тавьж ажиллах чиглэл, зөвлөмж өгөх, Орон тооны бус зөвлөлд танилцуулж, хэлэлцүүлэн, зөвлөмж гарган, үйлчилгээ эрхлэгчдэд хүргүүлж ажиллалаа. Энэ талаар иргэд, олон нийттэй харилцах 11-11 төвд болон гомдол гаргасан тухайн иргэдэд хариу тайлбар, мэдээлэл өгөн ажиллаж байна.

Тайлант хугацаанд Орон тооны бус зөвлөлийн ээлжит 3 удаагийн хурлыг зохион байгуулсан. Хурлаар тус Хорооноос хийдэг радио, телевизийн хөтөлбөрийн хяналт, мониторингийн тайлангаас насанд хүрэгчдэд зориулсан контентыг 06-22 цагийн хооронд нэвтрүүлсэн зөрчлийн тайланг нэгтгэн гаргаж хэлэлцүүлсэн. Улаанбаатар хотын телевизүүдэд 2024 оны байдлаар 06-22 цагийн хооронд 18+ тэмдэглэгээтэй кино, нэвтрүүлэг нэвтрүүлсэн мөн өдрийн цагаар стандартын дагуу насны ангиллын тэмдэглэгээг зөв тавиагүй нийт 510 зөрчил бүртгэгдсэн байна. Эдгээр зөрчлүүдийг нэг бүрчлэн хянан үзсэний үндсэн дээр нийт 28 телевизийн зөрчилд хүүхдэд зохисгүй агуулга нэвтрүүлсэн эсэх асуудлыг Зөвлөлийн хуралдаанаар хэлэлцсэн. Хуралдааны шийдвэрээр 16



телевизийг зохисгүй агуулга нэвтрүүлсэн гэж үзэн мэдэгдэл хүргүүлж, 5 телевизэд зөвлөмж өгч ажиллалаа.

Өдрийн цагаар 18+ кино, нэвтрүүлэг нэвтрүүлсэн зөрчлийн талаар, мөн иргэдээс ирүүлсэн гомдлын талаар хэлэлцүүлж холбогдох шийдвэр гаргуулан, үйлчилгээ эрхлэгчдэд зөвлөмж хүргүүлсэн. Түүнчлэн 2024 онд хийгдэх шторкийн агуулга, Кино урлагийн зөвлөл, өргөн нэвтрүүлгийн орчинд хүүхдийг зохисгүй агуулгаас хамгаалах чиглэлээр НҮБ-ийн дэмжлэгтэй хийж, хэрэгжүүлэх боломжтой үйл ажиллагааны санал бэлтгэн танилцуулж, гишүүдээс санал авч ажилласан. Зөвлөлийн хурлаар хэлэлцсэн гомдол, зөвлөлийн ажилласан тайлан, мэдээг бэлтгэн цахим хуудсанд байршуулж олон нийтэд мэдээлсэн. (<https://www.crc.gov.mn/articles/mn>).

Хүүхдийг зохисгүй агуулгаас хамгаалах радио, телевизийн хөтөлбөрийн дүрэм болон Орон тооны бус зөвлөлийг олон нийтэд таниулах зорилгоор “Хүүхдийн өмнөөс хэн ч гомдож болно” гарчиг бүхий мэдээг бэлтгэн <https://www.zms.mn>, <https://gogo.mn> сайтуудад нийтлүүлсэн. Мөн ХХЗХ-ны 2024 оны хагас жилийн сэтгүүлд “Зөвлөл байгуулагдан радио телевизийн үйлчилгээ эрхлэгчдэд сургалт, мэдээлэл хийснээр зөрчлийн тоо буурч байна” нэртэй ярилцлага нийтлүүлсэн.

Түүнчлэн зөрчил давтан гаргасан 14 телевизийн холбогдох мэргэжилтнүүдэд Зөвлөлийн гишүүн Г.Гүнжидмаа, СЭМҮТ-ийн эмч Е.Гүлжинат нар “Хэвлэл мэдээллийн өөрийн зохицуулалт ба ёс зүй-хүүхэд хамгаалах асуудал”, “Дэлгэцийн хамаарал ба Хүүхдийн сэтгэхүй, бие махбодод сөрөг агуулгын үр нөлөө” сэдвүүдээр, Хорооны нийт албан хаагчдад Зөвлөлийн гишүүн Ж.Гантулга “Сэтгэл зүйн эрүүл мэнд” “Стресс менежмент” сэдвүүдээр сургалт хийж, зөвлөгөө мэдээлэл өгч ажиллалаа.

Хүүхдийг зохисгүй агуулгаас хамгаалах радио, телевизийн хөтөлбөрийн дүрэм болон Орон тооны бус зөвлөлийн үйл ажиллагааг үзэгч, олон нийтэд таниулах зорилгоор нийт дараах 6 видео контентыг бэлтгэн телевизүүдээр нэвтрүүлж байна. Эдгээр нь:

- Хүүхдийн бие махбод, сэтгэхүйд сөргөөр нөлөөлөх хүнсний бүтээгдэхүүн;
- Хүүхдийн эрх хүүхэд хамгаалал, Орон тооны бус зөвлөл ажиллаж байгаа талаарх мэдээлэл;
- Хүүхдийг дэлгэцийн хамаарлаас хамгаалцаага;
- Телевизийн өргөн нэвтрүүлэгт хүүхдийг зохисгүй агуулгаас хамгаалъя /зөвлөмж/;
- Телевизийн нэвтрүүлэгт насны ангиллын тэмдэг тэмдэглэгээ байршуулах;
- Хүүхэд хамгааллын тухай хууль, телевиз, радио, олон сувгийн үйлчилгээ эрхлэгч нарын хүүхдийг зохисгүй агуулгаас хэрхэн хамгаалах эдгээр болно.

2025 онд радио сонсогчдод зориулан хүүхдийг зохисгүй агуулгаас хамгаалах талаар радио шторкыг бэлтгэн нэвтрүүлэхээр бэлтгэж байна.

## **II. ТАЙЛАНТ ХУГАЦААНД ХУУЛЬД ЗААСАН ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ ОЛГОСОН, СУНГАСАН, ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛСАН, ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙГ ТҮДГЭЛЗҮҮЛСЭН, СЭРГЭЭСЭН, ХҮЧИНГҮЙ БОЛГОСОН ТОО, МЭДЭЭ**

ХХЗХ-ноос 2024 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс 2025 оны 05 дугаар сарын 01-ний өдрийн хооронд өргөн нэвтрүүлгийн үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөл сонгон шалгаруулалтаар олгох, ӨНТХ-ийн 6.1.6-д заасан төрөлд тусгай зөвшөөрөл олгох, мөн тусгай зөвшөөрлийн хугацааг сунгах,

тусгай зөвшөөрөлд нэмэлт, өөрчлөлт оруулах, тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлэх, сэргээх, хүчингүй болгох, дуусгавар болох үйл ажиллагааг хууль тогтоомжид заасан үндэслэлийн дагуу дараах байдлаар хэрэгжүүлж ажилласан.

### Нэг. Нээлттэй сонгон шалгаруулалтаар олгох тусгай зөвшөөрлийн тоо тогтоосон байдал, сонгон шалгаруулалтын дүн

Зохицуулах хорооны 2024 оны 05 дугаар сарын 16-ны 114 тоот тогтоолоор Говь-Алтай, Завхан, Ховд, Увс, Сэлэнгэ, Төв аймаг тус бүр 1 радиогийн үйлчилгээ эрхлэх, 08 дугаар сарын 30-ны өдрийн 181 тоот тогтоолоор Монгол Улсын нутаг дэвсгэрт үйлчилгээ эрхлэх 1 арилжааны телевизийн үйлчилгээ эрхлэх, 10 дугаар сарын 30-ны өдрийн 211 тоот тогтоолоор Дорнод, Сүхбаатар, Дорноговь, Өмнөговь аймгуудад тус бүр 1 радиогийн үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрлийн тоог тогтоож, нээлттэй сонгон шалгаруулалт зарлахаар болсон. Нээлттэй сонгон шалгаруулалтыг ӨНТХ-ийн 10 дугаар зүйлийн 10.7, 10.9, 10.10 дахь заалтуудын дагуу зохион байгуулан, шаардлага хангасан хүсэлт гаргагчдад тусгай зөвшөөрөл олгон, тусгай зөвшөөрлийн гэрээ байгуулсан. Үйлчилгээний 2 төрөлд нийт 11 үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөл олгохоор сонгон шалгаруулалт явуулснаас бүгд олгогдсон.

Тусгай зөвшөөрлийн төрөл	Сонгон шалгаруулалтаар олгохоор зарласан тусгай зөвшөөрлийн тоо	Үүнээс	
		Олгосон	Татгалзсан
Арилжааны радио-Орон нутагт	11 (10 аймагт)	11	-
Арилжааны телевиз-Монгол улс	1	1	-

Ийнхүү сонгон шалгаруулалтаар Монгол монголчуудын сонсох ном ТББ Говь-Алтай, Завхан, Ховд, Увс аймгуудад, Дархан мэдээлэл төв ХХК Төв, Сэлэнгэ аймгуудад, Эх элгэн нутаг ХХК Дорнод, Сүхбаатар, Дорноговь, Өмнөговь аймгуудад, Гурван булаг дэвшил ХХК Өмнөговь аймаг, Лариёко медиа групп ХХК Улаанбаатар хотод үйлчилгээ эрхлэх арилжааны телевизийн үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөл олгосон.

### Хоёр. Төлбөртэй телевизийн төрөлд тусгай зөвшөөрөл олгох хүсэлт шийдвэрлэсэн байдал

Тусгай зөвшөөрлийн хүсэлтийн тоо	Үүнээс	
	Олгосон	Татгалзсан
1	1	-

Монгол контент ХХК нь VooMax нэртэйгээр төлбөртэй телевизийн үйлчилгээ эрхлэх хүсэлт ирүүлснийг хуулийн хүрээнд хянаж, шийдвэрлэсэн. Ийнхүү одоогийн байдлаар 22 төлбөртэй телевиз тусгай зөвшөөрөлтэйгээр үйл ажиллагаа явуулж байна.

### Гурав: Тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлсэн арга хэмжээний талаар

2024 онд тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлсэн өргөн нэвтрүүлгийн үйлчилгээ эрхлэгч байхгүй байна. Харин 2023 онд Монгол телевиз ХХК-ийн Монгол ТВ+1 суваг нь түдгэлзүүлсэн хугацаанд

зөрчлөө арилгасан тул тусгай зөвшөөрлийг 2024 оны 2 дугаар сард сэргээсэн. 2025 оны 3 дугаар сарын 17-ны өдрийн 90 дүгээр тогтоолоор Сарны чулуу анар ХХК-ийн ТВ6, Эгон ХХК-ийн Шоп Монголиа телевизүүдийн тусгай зөвшөөрлийг 90 хоногийн хугацаатай түдгэлзүүлээд байна.

### Дөрөв. Тусгай зөвшөөрлийн хугацаа сунгасан байдал

№	Тусгай зөвшөөрлийн төрөл	Сунгалт хийх хүсэлт ирүүлсэн тусгай зөвшөөрлийн тоо	Үүнээс	
			Сунгасан	Татгалзсан
1	Өргөн нэвтрүүлгийн телевиз-УБ хот	1	1	-
2	Өргөн нэвтрүүлгийн телевиз-Орон нутаг	4	4	-
3	Арилжааны телевиз-УБ хот	8	8	-
4	Арилжааны радио	7	7	-
5	Олон суваг дамжуулах үйлчилгээ	4	4	-

2024 он болон 2025 оны эхний 5 сарын байдлаар өргөн нэвтрүүлгийн 24 үйлчилгээ эрхлэгч тусгай зөвшөөрөд сунгуулах хүсэлтээ хуулийн хугацаанд ирүүлснийг хянаж шийдвэрлэсэн байна.

### Тав. Тусгай зөвшөөрлийг хүчингүй болгосон байдал

№	Тусгай зөвшөөрлийн төрөл	Хүчингүй болсон тусгай зөвшөөрлийн тоо	Үндэслэл
1	Арилжааны телевиз-УБ хот	3	ЗтХ-ийн 6.2 дугаар зүйлийн 1.2. зөвшөөрлийг түдгэлзүүлсэн хугацаанд зөрчлөө арилгаж, зөвшөөрлийг сэргээлгэх тухай хүсэлтийг ирүүлээгүй -1 <sup>1</sup>  ӨНТХ-ийн 17.1.1 тусгай зөвшөөрлийн хүчин төгөлдөр байх хугацаа дууссан-2 <sup>2</sup>
2	Арилжааны радио	2	ЗтХ-ийн 6.2 дугаар зүйлийн 1.1 зөвшөөрөл эзэмшигч хүсэлт гаргасан – 2 <sup>3</sup>
3	Өргөн нэвтрүүлгийн телевиз-Орон нутаг	1	ЗтХ-ийн 6.2 дугаар зүйлийн 1.2. зөвшөөрлийг түдгэлзүүлсэн хугацаанд зөрчлөө арилгаж, зөвшөөрлийг сэргээлгэх тухай хүсэлтийг ирүүлээгүй – 1 <sup>4</sup>

<sup>1</sup> Байсикл медиа ХХК

<sup>2</sup> Эн Би Жи Кинг Монголиа ХХК-ийн Нийслэл ТВ, Эс Си Эйч ХХК-ийн Суваг 1

<sup>3</sup> Номин макс ХХК-ийн ФМ 104.5, Рашаантын баясгалан ХХК-ийн Эх нутаг ФМ 107

<sup>4</sup> Эм Юу Ти Эй ХХК-ийн Саян ТВ

4	Олон суваг дамжуулах үйлчилгээ	2	ЗТХ-ийн 6.2 дугаар зүйлийн 1.1 зөвшөөрөл эзэмшигч хүсэлт гаргасан - 1 <sup>5</sup>
---	--------------------------------	---	--

### Зургаа. Тусгай зөвшөөрөлд нэмэлт, өөрчлөлт оруулсан байдал

№	Тусгай зөвшөөрлийн төрөл	Нэмэлт, өөрчлөлт оруулсан тусгай зөвшөөрлийн тоо, нэр	Үүнээс		
			Тусгай зөвшөөрлийг шилжүүлсэн, хуулийн этгээдийн нэр өөрчлөгдсөн	Үйлчилгээ эрхлэх хүрээ өөрчилсөн	Үйлчилгээний нэр өөрчилсөн
1	Арилжааны телевиз-УБ хот	4	1	1	2
2	Өргөн нэвтрүүлгийн телевиз-Орон нутаг	2	2	-	45
3	Олон суваг дамжуулах үйлчилгээ	1	-	1	-

### III. ӨРГӨН НЭВТРҮҮЛГИЙН ҮЙЛЧИЛГЭЭ ЭРХЛЭХ ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛТЭЙ ЭТГЭЭДИЙН ЭЗЭМШЛИЙН ТАЛААРХ МЭДЭЭЛЛИЙГ ИЛ ТОД БАЙЛГАХ ЗОХИЦУУЛАЛТ, ХЭРЭГЖИЛТИЙН НӨХЦӨЛ БАЙДАЛ, ҮНЭЛЭЛТ, ДҮГНЭЛТ

ӨНТХ-ийн 19 дүгээр зүйлийн 19.1-т заасны дагуу өргөн нэвтрүүлгийг хараат бус, нээлттэй, ёс зүйтэй байлгах зорилгоор өргөн нэвтрүүлгийн эзэмшлийг ил тод байлгахаар зохицуулсан.

Өргөн нэвтрүүлгийн тухай хуульд өргөн нэвтрүүлгийг хараат бус, нээлттэй, ёс зүйтэй байлгах зорилгоор өргөн нэвтрүүлгийн үйлчилгээний эзэмшлийг ил тод байдлыг хангах тодорхой зохицуулалтуудыг тусгасан байдаг. Тухайлбал:

- “Өргөн нэвтрүүлгийг хараат бус, нээлттэй, ёс зүйтэй байлгах зорилгоор өргөн нэвтрүүлгийн эзэмшлийг ил тод байлгана.” (19.1 дэх хэсэг);
- “Тусгай зөвшөөрөл эзэмшигч хуулийн этгээд нь Зохицуулах хороонд жил бүрийн 12 дугаар сарын 31-ний өдрийн дотор тусгай зөвшөөрлийн эзэмшлийн талаарх тус хуульд заасан мэдээллийг хүргүүлнэ” (19.1 дэх хэсэг);
- “Тусгай зөвшөөрлийн эзэмшлийн зэмшлийн талаарх мэдээллийг Зохицуулах хороо олон нийтэд мэдээлнэ”(19.5);
- Өргөн нэвтрүүлгийн үйлчилгээний тусгай зөвшөөрлийн эзэмшлийн мэдээллийг Зохицуулах хороонд гаргаж өгөөгүй, нуусан тохиолдолд тусгай зөвшөөрлийг цуцлах хүртэл арга хэмжээ авна” (19.6) гэж тус тус заасан байдаг.

<sup>5</sup> Сансар дижитал ХХК, Мандал ширхэнцэг ХХК

- өргөн нэвтрүүлгийн үйлчилгээ эрхлэгчдийн эзэмшлийг олон нийтэд ил тод мэдээлэх, хэт төвлөрөл бий болохоос сэргийлэх арга хэмжээг авч хэрэгжүүлэх (30.1.2);

ХХЗХ-оос хуульд заасан дээрх бүрэн эрх, чиг үүргийг хэрэгжүүлж, тус хорооноос тусгай зөвшөөрөлтэй өргөн нэвтрүүлгийн үйлчилгээ эрхлэгчдээс (радио, телевизийн үйлчилгээ эрхлэгч, олон суваг дамжуулах үйлчилгээ эрхлэгч, радио, телевизийн газрын сүлжээний үйлчилгээ эрхлэгч) эзэмшлийн мэдээллийг хүлээн авч, жил бүрийн 12 дугаар сарын 31-ний байдлаар хүлээн авч, нэгтгэн 1-р улиралд багтаан олон нийтэд ил тод мэдээлэн ажиллаж байна.

Өргөн нэвтрүүлгийн тусгай зөвшөөрөл эзэмшигч нийт 243 үйлчилгээ эрхлэгчдээс олон нийтийн статустай 9 радио, телевиз болон төрийн өмчит үйлдвэрийн газар, УТҮГ нийт 3 үйлчилгээ эрхлэгчид, 20 нь ТББ-ын эзэмшилд байна.

- 2024 оны 12-р сарын 31-ний байлаар өргөн нэвтрүүлгийн үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрлийн эзэмшлийн мэдээллийг авч үзэхэд:

#### Хүснэгт 2.Тусгай зөвшөөрөл эзэмшигчдийн эрх зүйн статус

Өргөн нэвтрүүлгийн үйлчилгээ эрхлэгчид нийт тоо	Тусгай зөвшөөрөл эзэмшигчийн эрх зүйн статус									
	НЭЗХЭ (Олон нийтийн)	УТҮГ	ТӨҮГ	ХХК	ТББ	ХМБ*	Нөхөрлөл	ХК	ШБ**	Иргэн
243	9	1	2	204	20	3	1	1	1	1

*\*Өргөн нэвтрүүлгийн тухай хуулийн 7.2-т “өргөн нэвтрүүлгийн үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрлийг Монгол Улсад бүртгэлтэй хуулийн этгээдэд олгоно”. гэж заасан байдаг.*

Тайлбар: \*Хэвлэл мэдээллийн байгууллага, ШБ\*\*- Шашны байгууллага

Зохицуулах хороо нь өргөн нэвтрүүлгийн үйлчилгээ эрхлэгчдийн эзэмшлийн мэдээллийг хүлээн авч, Улсын бүртгэлийн ерөнхий газрын нээлттэй мэдээллийн сан (opendata.mn) -тай тулгаж шалгасны үндсэн дээр эзэмшлийн мэдээллийг эцэслэн гаргадаг.

ХХЗХ-ноос өргөн нэвтрүүлгийн үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөлтэй үйлчилгээ эрхлэгчдийн эзэмшлийн 2024 оны мэдээлэлтэй тус хорооны цахим хуудас <https://www.crc.gov.mn/list/rg-n-nevtr-leg/mn?show=304>-с дэлгэрэнгүй танилцах боломжтой.

## IV. ӨРГӨН НЭВТРҮҮЛГИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАХ ЗЭЭЛ, ӨРСӨЛДӨӨНИЙ НӨХЦӨЛ БАЙДЛЫН ТАЛААРХ СУДАЛГАА, ҮНЭЛЭЛТ, ДҮГНЭЛТ

### Нэг. Монгол Улсын хүн ам, өрхийн тоо, нягтралын байдал

Үндэсний Статистикийн хорооны статистикийн тайлангаар 2024 оны байдлаар Монгол Улсын нийт хүн ам 3,544,835, өрхийн тоо 997,023 байгаагаас Улаанбаатар хотын хүн ам 1,768,151, өрх 475,117, орон нутгийн хүн ам 1,776,684, өрхийн тоо 521,906 байна. Хүн амын тоо 2023 онтой харьцуулахад улсын хэмжээнд 1.1%-иар, Улаанбаатар хотын хувьд 1.9%, орон нутагт 0.4%-иар тус тус өссөн байна.

Хүн амын нягтралын түвшин 2024 онд Монгол Улсын хэмжээнд 2.3, баруун бүсийн хэмжээнд 1, хангайн бүс 1.6, төвийн бүс 1.1, зүүн бүс 0.8 байгаа нь өмнөх оныхтой ижил үзүүлэлттэй байгаа бол Улаанбаатар хотын хэмжээнд 376.2 болж нэмэгдсэн нь 2023 онтой харьцуулахад 7.1-ээр нэмэгдсэн үзүүлэлтийг үзүүлжээ.

Дэлгэрэнгүй мэдээллийг Үндэсний статистикийн хорооны <https://www.1212.mn/mn> сайтаас үзэх боломжтой.

### Хоёр. Өргөн нэвтрүүлгийн үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөлтэй этгээдийн тоо

ХХЗХ-ноос тусгай зөвшөөрөлтэй өргөн нэвтрүүлгийн үйлчилгээ эрхлэгчдийн тоо 2025 оны 05 дугаар сарын 01-ний өдрийн байдлаар 243 байна.

№	Үйлчилгээний төрөл	Үйлчилгээ эрхлэгчийн тоо
1	Радио, телевизийн газрын сүлжээний үйлчилгээ	1
2	Олон нийтийн телевиз, радио	Телевиз – 5 Радио - 4
3	Олон суваг дамжуулах үйлчилгээ	Улаанбаатар хот – 12 Орон нутагт - 15
4	Арилжааны телевизийн үйлчилгээ	Улаанбаатар хот –53 Орон нутагт – 3
5	Өргөн нэвтрүүлгийн телевизийн үйлчилгээ	Улаанбаатар хот –18 Орон нутагт – 44
6	Радиогийн үйлчилгээ эрхлэгч	Улаанбаатар хот –30 Орон нутагт - 36
7	Төлбөртэй телевиз	22
	НИЙТ	243

### Гурав. Өргөн нэвтрүүлгийн үйлчилгээний зах зээлийн багтаамж, хэмжээ, хэрэглэгчийн тоо, өрсөлдөөний нөхцөл байдал

#### Телевизийн зах зээлийн хэмжээ, бүтэц:

2024 оны статистикийн тайланд дурдсанаар Монголын телевизийн зах зээлийн нийт хэмжээ 120.4 тэрбум төгрөгт хүрч, өмнөх оноос 26.3%-иар өссөн байна. Энэ нь телевизийн салбарын нийт орлого тогтвортой өсөлтийн чиг хандлагатай байгааг харуулахын зэрэгцээ зар сурталчилгаа болон бусад эх үүсвэрээс орж буй орлогын урсгал идэвхжсэнээр салбарын эдийн засгийн эргэлт нэмэгдэж буйг илтгэж байна.

Дараах хүснэгтээр 2021–2024 оны телевизийн зах зээлийн хэмжээ, бүтцийг харуулав:

*Тэрбум төгрөгөөр*

Зах зээлийн хэмжээ	2021 он	2022 он	2023 он	2024 он
Өргөн нэвтрүүлгийн телевизийн зах зээл	44.6	55.3	61.4	81.0
Арилжааны телевизийн зах зээл	25.1	21.9	33.9	39.4
Телевизийн нийт зах зээл	69.7	77.2	95.3	120.4

2024 оны байдлаар:

- өргөн нэвтрүүлгийн телевизийн зах зээл нийт зах зээлийн 67.2%,
- арилжааны телевизийн зах зээл 32.7%-ийг тус тус эзэлж байна.

Энэ нь өргөн нэвтрүүлгийн телевизийн орлого зах зээлд давамгайл хэвээр байгааг харуулж байна.

Зах зээлийн орлогын дийлэнх хэсгийг Улаанбаатар хотод үйл ажиллагаа явуулдаг телевизүүд бүрдүүлж байна. Тухайлбал 2024 онд:

- Өргөн нэвтрүүлгийн телевизийн зах зээлийн орлогын 96.7%-ийг Улаанбаатар хотын, Монгол Улсад хамрах хүрээтэй өргөн нэвтрүүлгийн 18 телевиз, үлдсэн 3,3%-ийг орон нутгийн 47 телевиз тус тус бүрдүүлж байна.
- Арилжааны телевизийн зах зээлийн орлогод 2024 онд 99.9%-ийг Улаанбаатар хотын (МУ-д хамрах хүрээтэй 39) арилжааны 53 телевиз, үлдсэн хувийг орон нутгийн 3 арилжааны телевиз бүрдүүлж байна.

2024 оны статистикийн дүнгээс харахад:

- Улаанбаатар хотын өргөн нэвтрүүлгийн телевизийн зах зээлийн 61.9%-ийг топ 4 телевиз дангаар эзэлж байна.
- Зах зээлийн 2-6 % хувийг тогтвортой хадгалж буй бусад 7 телевизийг нэмбэл нийтдээ зах зээлийн 87.3%-ийг эдгээр 11 телевиз бүрдүүлж байна.
- Үлдсэн 12.7%-ийг бусад 7 телевиз хуваан эзэлж байгаа бөгөөд тус бүр зах зээлийн 2 %-иас бага хувийг эзэлж байна.

Зах зээлд өрсөлдөөн тодорхой хэмжээнд байгаа ч телевизийн зах зээлийн гол орлого цөөн тооны компаниудад төвлөрсөн хэвээр байна.

Зах зээлийн төвлөрөл, өрсөлдөөний түвшний дүгнэлт (2020–2024):

УБ хотын өргөн нэвтрүүлгийн телевизийн зах зээлийн төвлөрөл	2020 он	2021 он	2022 он	2023 он	2024 он
Төвлөрлийн хувь (CR)	64%	56%	43%	59%	62%
Херфиндал - Хиршман Индекс (НИИ)	1116	1093	949	815	1031

Зах зээл дэх төвлөрлийн түвшин (Concentration ratio<sup>6</sup>, төвлөрлийн түвшин, цаашид CR гэх) Зах зээл дэх төвлөрлийн түвшний (CR) болон өрсөлдөөний индекст (НИИ) тулгуурласан 2020–2024 оны үзүүлэлтээс харахад Улаанбаатар хотын өргөн нэвтрүүлгийн телевизийн зах зээлд дунд зэргийн төвлөрөл ажиглагдаж байна. Тухайлбал:

2020 онд CR 64%, өрсөлдөөний түвшин (Herfindahl–Hirschman index<sup>7</sup>, өрсөлдөөний түвшин, (цаашид НИИ гэх)) НИИ 1116-тай байснаар зах зээл дунд зэрэг төвлөрсөн, өрсөлдөөн дунд түвшинд байгааг харуулж байсан бол 2023 онд CR 59%, НИИ-815 болж буурсан нь зах зээлийн бүтэц илүү тэнцвэртэй болж, үйлчилгээ эрхлэгчдийн зах зээлд эзлэх хувь ойролцоо, зарим телевизүүдийн давамгайл байдал суларсныг илтгэж байна. Энэ нь зах зээлд төвлөрөл буурч, өрсөлдөөний түвшин нэмэгдсэн үзүүлэлт юм.

Харин 2024 онд CR 62%, НИИ 1031 болж өссөн нь зах зээлийн төвлөрлийн түвшин дахин нэмэгдэж, өрсөлдөөн дунд түвшинд хадгалагдаж буйг харуулж байна. Эдгээр үзүүлэлт нь зах зээлд хангалттай тооны тоглогч байгааг илтгэх боловч томоохон телевизүүдийн зах зээлд эзлэх нөлөө дахин нэмэгдэх хандлагатай байгааг илэрхийлж байна.

Нөгөө талаар Улаанбаатар хотын өргөн нэвтрүүлгийн телевизийн үйлчилгээ эрхлэгчдийн зардал сүүлийн 5 жилд тогтмол өсч байна. Үүнд:

2020 онд- 30,9 тэрбум төгрөг  
2021 онд -40,1 тэрбум төгрөг,  
2022 онд- 43,9 тэрбум төгрөг,  
2023 онд - 54,6 тэрбум төгрөг,  
2024 онд- 64,8 тэрбум төгрөг байна.

2024 онд өргөн нэвтрүүлгийн телевизийн үйлчилгээ эрхлэгчид салбарт нийт 9,1 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалт хийгдсэнээс 8,4 тэрбум төгрөг буюу 92 %-ийг Улаанбаатар хотын өргөн нэвтрүүлгийн телевизүүд, харин 721 сая төгрөгийг орон нутгийн өргөн нэвтрүүлгийн телевизүүдийн бүрдүүлсэн байна.

Статистик тайлан ирүүлсэн арилжааны телевизийн үйлчилгээ эрхлэгчдийн тоо 2020-2024 оны хооронд хэлбэлзэлтэй байсан ч (2020 онд 28, 2021 онд 36, 2022 онд 29, 2023 онд 43, 2024 онд 40) сүүлийн жилүүдэд тогтмол өсч байгааг харуулж байна. Энэ нь телевизийн салбарын зах зээлийн статистик мэдээллийг илүү үнэн зөв, бүрэн гүйцэт цуглуулах, дүн шинжилгээ хийх суурь нөхцлийг бүрдүүлж байна.

Арилжааны телевизийн зах зээлд топ 4 телевизийн эзлэх хувь 2022 онд 76% байсан бол 2023 онд 87%-д хүрч өссөн ч 2024 онд 84% болж өмнөх оноос бага зэрэг буурсан байна.

<sup>6</sup> Төвлөрлийн харьцааны индекс нь 1-ээс 100 хувийн утга авах бөгөөд үүгээр тухайн зах зээлийн төвлөрөл, өрсөлдөөний нөхцөл байдлыг тодорхойлно. Өрсөлдөөний зохицуулалтын практикт ихэнхдээ зах зээл дэх 3, 4, эсвэл 5 томоохон үйлчилгээ эрхлэгчийн төвлөрлийг тодорхойлж үздэг ба хэрэв индексийн утга 80-100 бол төвлөрлийн түвшин өндөр, 50-80 бол төвлөрлийн түвшин дундаж, 0-50 бол төвлөрлийн түвшин бага гэж үзнэ.

<sup>7</sup> Энэхүү индекс нэгтэй тэнцүү байх нөхцөлд тухайн зах зээлд зөвхөн нэг үйлчилгээ эрхлэгч (монопол) байна. Хэрэв индексийн утга ХХИ<ХХИ1800 бол тухайн зах зээлд төвлөрлийн түвшин өндөр буюу өрсөлдөөн хязгаарлагдмал гэж үзнэ.

2020–2024 оны хооронд Улаанбаатар хотын арилжааны телевизийн зах зээлд төвлөрлийн түвшин ерөнхийдөө өндөр байсан бөгөөд CR үзүүлэлт 76–87 хувь, ННІ 1498–2999-ийн хооронд хэлбэлзэж, 2021 оныг эс тооцвол бусад жилүүдэд зах зээл "өндөр төвлөрсөн, өрсөлдөөн хязгаарлагдмал" ангилалд багтаж байлаа. Тухайлбал 2020 онд CR 84%, ННІ 1864 -тай байсан бол 2021 оноос хойш ННІ үзүүлэлт өссөн, зах зээлийн төвлөрөл нэмэгдэж, өрсөлдөөн улам бүр хязгаарлагдмал болсон нь цөөн тооны тоглогчид зах зээлийн голлох орлогыг бүрдүүлж байгааг илтгэнэ.

УБ хотын арилжааны телевизийн зах зээлийн төвлөрөл	2020 он	2021 он	2022 он	2023 он	2024 он
Төвлөрлийн хувь (CR)	84.1%	76%	83.3%	87%	84%
Херфиндал- Хиршман Индекс (ННІ)	1864	1498	1929	2999	2758

Улаанбаатар хотын арилжааны телевизийн үйлчилгээ эрхлэгчдийн зардал 2020-2024 онд хэлбэлзэж байсан ч ерөнхийдөө өсөх хандлагатай байна. Тухайлбал: зардал 2020 онд 23.9 тэрбум төгрөг байсан бол 2022 онд 19,5 тэрбум төгрөг болж саарсан хэдий ч 2023, 2024 онд эрс нэмэгдэж, 2023 онд 38 тэрбум төгрөг, 2024 онд 42,6 тэрбум төгрөг болж тус тус өсчээ. Харин арилжааны телевизийн үйлчилгээ эрхлэгчдийн салбарт оруулсан хөрөнгө оруулалт 2022 онд 4,6 тэрбум төгрөг байсан бол 2023 онд буурч 1 тэрбум төгрөгт болсон ч 2024 онд дахин өсч 6,2 тэрбум төгрөгт хүрсэн байна. Энэ нь арилжааны телевизүүдийн үйл ажиллагааны зардал нэмэгдэж буйтай уялдан хөрөнгө оруулалт идэвхжиж байгааг харуулж байна.

Нөгөө талаар арилжааны телевизүүдийн хувьд орлогоо тайлагнаагүй, эсхүл “Орлого” байхгүй гэж татистик мэдээлэл ирүүлсэн, зах зээлд 10 гаруй жил үйл ажиллагаа явуулж байгаа ч зардлаа нөхөж чадахгүй, санхүүгийн хувьд тогтвортой бус 10 орчим телевиз зах зээлд оршин тогтносон хэвээр байна. Эдгээр телевизүүд санхүүгийн хувьд тогтворгүй, үр ашиггүй бүтэцтэйгээр үйл ажиллагаа эрхлэж байгаа нь телевизийн салбарын санхүүгийн тогтвортой байдал, урт хугацааны эрүүл хөгжилд сөргөөр нөлөөлөх эрсдэлтэй юм.

Дээрх зах зээлийн өнөөгийн байдалд хийсэн дүн шинжилгээнээс үзэхэд арилжааны телевизүүдийн хувьд зах зээлийн төвлөрлийн түвшин харьцангуй өндөр, өрсөлдөөн хязгаарлагдмал байгааг харуулж байна. Нийт 54 арилжааны телевиз үйл ажиллагаа эрхлэж байгаа хэдий ч зах зээлийн ихэнх хувийг цөөн тооны телевизүүд эзэлж, үлдсэн олон тооны телевизийн оролцоо сул, зах зээлд үзүүлэх нөлөө бага байгаа нь бодит өрсөлдөөн хангалтгүй байгааг илтгэж байна. Зах зээлийн бүтэц, өрсөлдөөний нөхцөл нь зөвхөн телевизийн тоогоор бус, үйлчилгээ эрхлэгчдийн чадавхи, технологийн дэвшил, контентын чанар зэрэг хүчин зүйлээс ихээхэн хамаарч байна. Өнөөдөр өндөр чадавхитай, мэргэжлийн баг хамт олонтой, дэвшилтэт технологи ашиглан, үзэгчдийн хэрэгцээ шаардлагад нийцсэн чанартай контент үйлдвэрлэж чадах телевизүүд зах зээлд өрсөлдөх чадвартай байна. Иймд зах зээлийн бүтэц, өрсөлдөөний нөхцлийг сайжруулахын тулд зөвхөн телевизүүдийн тоон үзүүлэлтэд үндэслэх бус, үйлчилгээ эрхлэгчдийн үйл ажиллагааны чадавхи, тогтвортой үйл ажиллагаа эрхлэх боломж, зах зээлд шинэчлэл авчрах нөөц бололцоог харгалзан үзэх шаардлага тулгарч байна.

Иймээс зах зээлд чадавхитай, мэргэжлийн үйлчилгээ эрхлэгчдийг шинээр нэвтрэх боломжийг хангахын тулд зохицуулалтын хязгаарлалтыг аль болох оновчтой болгож, хэт хүндрэл учруулахгүй байх нь өрсөлдөөнийг нэмэгдүүлж, хөтөлбөрийн олон талт байдал, контентийн чанарыг сайжруулах чухал нөхцөл болно гэж үзэж байна.

### **Олон суваг дамжуулах үйлчилгээний зах зээл:**

Статистик тайлан ирүүлсэн олон суваг дамжуулах үйлчилгээ эрхлэгчдийн тоо 2021-2024 онд хэлбэлзэлтэй 2021 онд 31, 2022 онд 30, 2023 онд 26, харин 2024 онд 27 үйлчилгээ эрхлэгч тайлан мэдээ ирүүлсэн байна.

### **Олон суваг дамжуулах үйлчилгээний хэрэглэгчийн тооны өөрчлөлт (2021–2024)**

Олон суваг дамжуулах үйлчилгээний хэрэглэгчийн тоо сүүлийн дөрвөн жилд бага зэргийн хэлбэлзэлтэй байсан ч нийт дүнгээрээ аажмаар буурах хандлагатай байгааг харуулж байна. Тухайлбал, 2021 онд 808,463 идэвхтэй хэрэглэгч бүртгэгдсэн бол 2024 онд энэ тоо 753,790 болж, 2021 онтой харьцуулахад 6.76%-иар буурсан байна.

2024 онд телевизийн олон суваг дамжуулах үйлчилгээг интернэтээр (ОТТ) хүлээн авч байгаа хэрэглэгчийн тоог сүүлийн 3 сарын хугацаанд төлбөр төлсөн идэвхтэй хэрэглэгчийн тоогоор авч үзэхэд 152,556-д хүрсэн байна. Энэ нь ОСДҮЭ-ийн нийт тоо буурсан хэдий ч нөгөө талд ОТТ хэрэглэгчдийн тоо нэмэгдсэн нь тухайн орон зайг ОТТ нөхөж байгааг харуулж байна

2024 оны байдлаар нийт өрхийн 75.2 %- олон суваг дамжуулах үйлчилгээг хүлээн авч байна Улаанбаатар хотод бүртгэгдсэн идэвхтэй хэрэглэгчийн тоо 2021 онд 456,691 байсан бол 2024 онд 448,000 болж, харьцангуй тогтвортой түвшинд хадгалагдаж байна. Харин орон нутгийн хэрэглэгчийн тоо 2021 оны 351,772-оос 2024 онд 305,800 болж буурсан нь нийт хэрэглэгчийн тоо буурахад голлон нөлөөлсөн байна.

Хэрэглэгчийн тооны энэхүү судалгааг телевизийн олон суваг дамжуулж байгаа технологийн төрөл, үйлчилгээ эрхлэгч, үйлчилгээ эрхлэх хүрээгээр ялган гаргасан.

<b>Олон сувгийн хэрэглэгчийн тоо</b>	<b>2021 он</b>	<b>2022 он</b>	<b>2023 он</b>	<b>2024 он</b>
<b>Нийт идэвхтэй хэрэглэгч</b>	<b>808,463</b>	<b>760,028</b>	<b>761,800</b>	<b>753,790</b>
Үүнээс Улаанбаатар хот	456,691	424,925	447,738	448,000
Үүнээс Орон нутаг	351,772	335,103	314,062	305,800



2024 оны байдлаар Улаанбаатар хотод олон суваг дамжуулах үйлчилгээний идэвхтэй хэрэглэгчийн тоо 448,000-д хүрсэн бөгөөд сүүлийн жилүүдэд (2021–2024) 420–460 мянган хэрэглэгчийн хооронд хэлбэлзэж байна. Эдгээр хэрэглэгчдийн 93% нь төвийн зургаан дүүрэгт харьяалагддаг бол үлдсэн 7% нь алслагдсан гурван дүүрэгт (Багануур, Багахангай, Налайх) байршиж байна. Зах зээлийн нэвтрэлтийн түвшин нийслэлийн хэмжээнд дунджаар 103% байгаа нь зарим өрхүүд давхар үйлчилгээ авч байгааг илтгэж байна. Харин орон нутагт энэхүү үзүүлэлт дунджаар 56%-тай байгаа нь нийслэлтэй харьцуулахад зах зээлийн нэвтрэлт бага байгааг харуулж байна.

**Олон суваг дамжуулах үйлчилгээний зах зээлийн хэмжээ** 2022 онд 181,38 тэрбум төгрөг байсан бол 2023 онд 212,77 тэрбум төгрөг, 2024 онд 259,28 тэрбум төгрөгт хүрч, зах зээлийн хэмжээ тасралтгүй өссөн байна. 2024 онд олон суваг дамжуулах үйлчилгээний нийт орлого өмнөх оноос 21,8%-иар өссөн үүнд интернэт протоколд (IP TV зэрэг) суурилсан үйлчилгээний орлого 33,2%-аар нэмэгдсэн нь голлон нөлөөлжтэй. Харин бусад уламжлалт бусад технологи бүхий үйлчилгээний орлого буурсан үзүүлэлттэй байна.

Олон суваг дамжуулах үйлчилгээний зах зээлд дижитал шилжилт эрчимтэй өрнөж байна. Хэрэглэгчдийн хэрэглээ уламжлалт технологиос интернетэд суурилсан, ухаалаг төхөөрөмжөөр хүссэн үедээ хандах боломжтой үйлчилгээнд шилжиж буйг зах зээлийн хандлага тод харуулж байна. Тухайлбал уламжлалт ОСДҮЭ-ийн хэрэглэгчийн тоо буурах хандлагатай байгаа бол интернет протоколд суурилсан IPTV хэрэглэгчид жилд дунджаар 15%-иар тогтмол өсч, үүний зэрэгцээ ОТТ үйлчилгээний хэрэглээ ч мөн эрчимтэй нэмэгдэж байна. Эдгээр үзүүлэлтүүд нь олон нийт контентоо улам бүр дижитал, ухаалаг, хэрэглэгч төвтэй хэлбэрээр хүлээн авах сонирхолтой болж байгааг илтгэж байна.

**Зардал:** 2023 онд олон суваг дамжуулах үйлчилгээ эрхлэгчдийн нийт зардал 108.2 тэрбум төгрөгт хүрсэн нь өмнөх оноос 57%-иар өссөн үзүүлэлттэй байна. Үүний зэрэгцээ хөрөнгө оруулалтын хэмжээ сүүлийн жилүүдэд тасралтгүй буурч, 2021 онд 36.1 тэрбум төгрөг байсан бол 2024 онд 11.5 тэрбум төгрөгт хүрч огцом буурсан байна.

Улсын төсөвт төвлөрүүлсэн орлогын хэмжээ хэлбэлзэлтэй боловч 2024 онд 48.5 тэрбум төгрөг болж нэмэгдсэн нь 2023 оны (39.2 тэрбум төгрөг) үзүүлэлтээс 24%-иар өссөн байна.

Нэгж хэрэглэгчээс олох сарын дундаж орлого тогтмол өсөх хандлагатай байгаа бөгөөд 2022 онд 17,530 төгрөг байсан бол 2023 онд 19,767 төгрөг, 2024 онд 23,982 төгрөг болж нэмэгдсэн байна.

Олон суваг дамжуулах үйлчилгээний зах зээлд төвлөрлийн түвшин сүүлийн дөрвөн жилийн хугацаанд тогтмол өсөж, зах зээлийн өрсөлдөөн улам бүр хумигдсан байна. Үүнийг дараах гол үзүүлэлтүүд илтгэж байна:

Өрсөлдөөний нөхцөл байдал	2021 он	2022 он	2023 он	2024 он
Төвлөрлийн хувь (CR)	86%	94%	94.2%	96.6%
Херфиндал-Хиршман Индекс (HHI)	2700	3644	4292	5000

Зах зээл дэх төвлөрлийн хувь 2021 онд CR 86% бол 2024 онд 96.6%-д хүрч, зах зээлийн голлох хэсгийг цөөн хэдэн үйлчилгээ эрхлэгчид төвлөрсөн байгааг харуулж байна.

Харин өрсөлдөөний түвшинг илэрхийлдэг Херфиндал-Хиршман индекс (ННН) 2021 онд 2700 байсан бол 2024 онд ННН 5000 -д хүрсэн нь зах зээл өндөр төвлөрөлтэй, өрсөлдөөн хязгаарлагдмал түвшинд очсоныг илтгэж байна.

### **Радиоогийн зах зээлийн хэмжээ:**

Сүүлийн таван жилийн байдлаар радиоогийн зах зээл тогтвортой өсөлттэй байна. Зах зээлийн нийт хэмжээ 2020 онд 1.5 тэрбум төгрөг байсан бол 2024 онд 5 тэрбум төгрөгт хүрч, таван жилийн хугацаанд **3.3 дахин нэмэгдсэн** байна.

Он	Зах зээлийн хэмжээ (тэрбум ₮)	Зардал (тэрбум ₮)
2020	1,5	1.9
2021	2.2	1.6
2022	3.3	1.7
2023	3.9	2.3
2024	5	3.3

2024 оны байдлаар нийт орлогын **91%** нь Улаанбаатар хотын радиоогийн үйлчилгээ эрхлэгчдээс бүрдэж байгаа бөгөөд үүний ойролцоогоор 80%-ийг нэг үйлчилгээ эрхлэгч дангаар бүрдүүлж байна.

Зардлын хувьд 2020–2022 онд тогтвортой түвшинд хадгалагдаж байсан бол 2023–2024 онд огцом өссөн бөгөөд 2024 онд нийт зардал **3.3** тэрбум төгрөгт хүрч, өмнөх оноос 43%-иар нэмэгдсэн үзүүлэлттэй байна.

Радиоогийн зах зээл тогтвортой өсөлттэй байгаа нь радиоогийн үйлчилгээний орлого тасралтгүй нэмэгдэж, зах зээлд тогтвортой өсөлтийн чиг хандлага хадгалагдаж байгааг харуулж байна.

### Радиоогийн зах зээлийн төвлөрлийн түвшин.

Он	Төвлөрлийн хувь (CR)	Херфиндал-Хиршман индекс (ННН)
2021	90 %	4719
2022	91 %	4674
2023	93 %	6039
2024	90.1 %	6542

Сүүлийн дөрвөн жилийн хугацаанд радиоогийн зах зээлд төвлөрлийн түвшин өндөр байдал тогтвортой байгаа нь өрсөлдөөний орчин хязгаарлагдмал, цөөн тооны үйлчилгээ эрхлэгч зах зээлийг давамгайлж байгааг харуулж байна.

CR үзүүлэлт 90%-иас дээш түвшинд тогтвортой хадгалагдаж байгаа бөгөөд ННН үзүүлэлт 2021-2022 онд гэхэд л төвлөрлийн өндөр түвшинд хүрснийг илэрхийлж байсан бол 2023 оноос эхлэн 6000-аас дээш өсөж, зах зээлд маш өндөр төвлөрөл үүссэн, өрсөлдөөн ч маш хязгаарлагдмал болсныг харуулж байна.

Радиоогийн үйлчилгээ эрхлэгчдийн салбарт оруулсан нийт хөрөнгө оруулалт 835,4 сая тэрбум төгрөг байна.

Харилцаа холбооны зохицуулах хорооноос гаргадаг хагас жил болон жилийн эцсийн салбарын үндсэн үзүүлэлт, статистик дата мэдээллийн дэлгэрэнгүйг <https://www.crc.gov.mn/list/zah-zeel-rs-ldn/mn?show=45> хуудаснаас он тус бүрээр дэлгэрүүлэн үзэх боломжтой ба салбарын 2024 оны жилийн эцсийн үндсэн үзүүлэлт, дата мэдээллийг <https://statistic.crc.gov.mn/#/infograph/4162> -с татан авч, танилцана уу.

### Дөрөв. Эрэлт, хэрэгцээ

ХХЗХ нь өргөн нэвтрүүлгийн үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөл олгохдоо өргөн нэвтрүүлгийн зах зээлийн багтаамж, хүн амын тоо, нягтрал, эрэлт хэрэгцээ, өрсөлдөөний нөхцөл байдлын талаарх судалгаанд үндэслэн тусгай зөвшөөрлийн тоог тогтоохоор хуульчилсан бөгөөд тухайн үйлчилгээг эрхлэх эрэлт, хэрэгцээ байгаа эсийг тодорхойлох зорилгоор судалгааны асуулга буюу мэдээлэл ирүүлэх маягт гаргаж өөрийн цахим хуудаст <https://shorturl.at/L2kWC> байршуулж сонирхогч эдгээдүүдээс мэдээлэл хүлээн авч ажиллаж байна.

Энэ дагуу 2020 онд ирүүлсэн судалгааг үндэслэн 2020 оны 91 тоот тогтоолоор, 2021 онд ирүүлсэн судалгааг үндэслэн 2021 оны 71 тоот тогтоолоор тус тус тусгай зөвшөөрлийн тоог баталж байсан бөгөөд 2021 оны тоо тогтоох судалгаа, дүгнэлтээр гарсан саналын дагуу нэр бүхий аймагт үйлчилгээ эрхлэх судалгааг дахин авч үзэж, мөн 2022, 2023 онд тус хороонд ирүүлсэн сонирхогч этгээдийн судалгаа, мэдээллийг нэгтгэж 2023 оны 35 тоот тогтоолоор тусгай зөвшөөрөл олгох тоог тогтоосон.

Сонгон шалгаруулалтаар 2021-2024 онуудад нийт олон суваг дамжуулах үйлчилгээний тусгай зөвшөөрөл олгох тоог 3 гэж тогтоосноос сонгон шалгаруулалтаар 2 тусгай зөвшөөрөл олгогдсон, өргөн нэвтрүүлгийн телевизийн тусгай зөвшөөрөл олгох нийт 18 тоо тогтоож сонгон шалгаруулалт зарласнаас 8 тусгай зөвшөөрөл олгогдсон, арилжааны телевизийн 2 тусгай зөвшөөрлийн тоо тогтоож сонгон шалгаруулалтаар 1 олгогдсон, орон нутагт радиоогийн 36 тусгай зөвшөөрлийн тоо тогтоосноос сонгон шалгаруулалтаар 19 тусгай зөвшөөрөл тус тус олгогдоод байна.

Дэлгэрэнгүйг тусгай зөвшөөрлийн төрөл, үйлчилгээ эрхлэх хүрээ тус бүрээр доорх хүснэгтэд үзүүлээ.

Зөвшөөрлийн тоо				Квот тогтоосон, сонгон шалгаруулалтаар олгосон байдал		
Зөвшөөрлийн төрөл	Монгол улс	УБ хот	Аймаг	МУ-ын нутаг дэвсгэрт	Аймагт	Нийт зарласан/ олгосон
Олон суваг дамжуулах	6	6	16	2021 онд 1/1 2023 онд 1/0	2023 онд 1 аймагт 1/1 (1 аймагт)	3/2

Өргөн нэвтрүүлгийн телевиз	21	-	41	-	2021 онд 8 аймагт 11/6 (6 аймагт) 2023 онд 7 аймагт 7/2 (2 аймагт)	18/8
Арилжааны телевиз	38	14	3	2024 онд 1/1	2023 онд 1 аймагт 1/0	2/1
Арилжааны радио	3	27	36	-	2021 онд 12 аймагт 12/2 (т.з гэрээ байгуулаагүй тул хүчингүй болгосон) 2022 онд 3 аймагт 3/2 (2 аймагт) 2023 онд 10 аймагт 10/6 (6 аймагт) 2024 онд 10 аймагт 11/11 (10 аймагт-4 үйлчилгээ эрхлэгч)	36/19

2025 онд Улаанбаатар хотод олон суваг дамжуулах үйлчилгээний 1 хүсэлт, арилжааны телевизийн 5 хүсэлт, Увс аймагт өргөн нэвтрүүлгийн телевизийн үйлчилгээ эрхлэх 1 хүсэлт тус тус ирсэн.

## V. ХОРООНООС 2025 ОНД НЭЭЛТТЭЙ СОНГОН ШАЛГАРУУЛАЛТААР ОЛГОХ ӨРГӨН НЭВТРҮҮЛГИЙН ҮЙЛЧИЛГЭЭ ЭРХЛЭХ ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙН ТОО ТОГТООХ ЭСЭХЭД БАРИМТАЛСАН ЗАРЧИМ, ХАРГАЛЗАН ҮЗСЭН ҮЗҮҮЛЭЛТ, ШИЙДВЭР

### Нэг. Өргөн нэвтрүүлгийн үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрлийн тоо тогтоох эсэхэд баримталсан зарчим, харгалзан үзсэн үзүүлэлтүүд

Өргөн нэвтрүүлгийн үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрлийн төрлийг ӨНТХ-ийн 6 дугаар зүйл, тусгай зөвшөөрөлтэй эрхлэх үйл ажиллагааг ЗТХ-ийн 8.1 дүгээр зүйлийн 9.2, 9.6, 9.7, 9.9 дэх заалтаар тус тус тогтоосон.

ӨНТХ-ийн 7 дугаар зүйлийн 7.1-д “Өргөн нэвтрүүлгийн үйлчилгээг Зохицуулах хорооноос олгосон тусгай зөвшөөрлийн дагуу эрхэлнэ.” гэж; 7 дугаар зүйлийн 7.4.2-т “өргөн нэвтрүүлгийн зах зээлийн багтаамж, хүн амын тоо, нягтрал, эрэлт хэрэгцээ, өрсөлдөөний нөхцөл байдлын талаарх судалгаанд үндэслэх;” гэж; 7.4.5-д “энэ хуулийн 6.1.3, 6.1.6-д зааснаас бусад төрлийн өргөн нэвтрүүлгийн үйлчилгээний тусгай зөвшөөрлийг нээлттэйгээр сонгон шалгаруулах;” гэж; 30 дугаар зүйлийн 30.1.9-д “өргөн нэвтрүүлгийн зах зээлийн багтаамж, хүн амын тоо, нягтрал, эрэлт хэрэгцээ, өрсөлдөөний нөхцөл байдлын талаарх судалгаанд үндэслэн тусгай зөвшөөрлийн тоог тогтоох;” гэж; 30.1.10-т “хуульд заасан тусгай зөвшөөрөл олгох, сунгах, тусгай зөвшөөрөлд нэмэлт, өөрчлөлт оруулах, тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлэх, сэргээх, хүчингүй болгох, тусгай зөвшөөрлийн нөхцөл, шаардлага болон холбогдох журмыг батлах, гэрээ байгуулах, биелэлтэд хяналт тавих;” гэж тус тус тодорхойлсны дагуу ХХЗХ-ноос өргөн нэвтрүүлгийн үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрлийг олгохтой холбоотой харилцааг хуульчилсан.



Зөвшөөрлийн тухай хууль батлагдаж 2023 оноос хүчин төгөлдөр мөрдөгдөж эхэлсэнтэй холбоотой ӨНТХ-д 2023 оны 01 дүгээр сарын 06-ны өдөр оруулсан нэмэлт, өөрчлөлтийн хүрээнд өргөн нэвтрүүлгийн үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрлийн тоо тогтоох, нээлттэй сонгон шалгаруулалтаар олгох журмыг тусгаж, үүнтэй холбоотой ХХЗХ-ны 2020 оны 64 дүгээр тогтоолоор баталсан “Өргөн нэвтрүүлгийн үйлчилгээ эрхлэх зөвшөөрлийн журам”-ыг тус хорооны 2023 оны 2 тоот тогтоолоор хүчингүй болгосон. ӨНТХ-ийн 10 дугаар зүйлийн 10.6-д “Зохицуулах хороо Зөвшөөрлийн тухай хуулийн 8.1 дүгээр зүйлийн 9.2, 9.6, 9.7, 9.9-д заасан тусгай зөвшөөрлийг сонгон шалгаруулалтаар олгоно.” гэж заасны дагуу өргөн нэвтрүүлгийн үйлчилгээ эрхлэх дараах төрлийн тусгай зөвшөөрлийг нээлттэй сонгон шалгаруулах зарчмыг баримтлан олгодог. Үүнд:

- Радио, телевизийн газрын сүлжээний үйлчилгээ эрхлэх;
- Олон суваг дамжуулах үйлчилгээ эрхлэх;
- Арилжааны радио, телевизийн үйлчилгээ эрхлэх;
- Өргөн нэвтрүүлгийн радио, телевизийн үйлчилгээ эрхлэх.

Өргөн нэвтрүүлгийн үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрлийн дээрх төрөлд нээлттэй сонгон шалгаруулалтаар тусгай зөвшөөрөл олгох тоо тогтооход ӨНТХ-ийн 30 дугаар зүйлийн 30.1.9-ийн дагуу өргөн нэвтрүүлгийн зах зээлийн багтаамж, хүн амын тоо, нягтрал, эрэлт хэрэгцээ, өрсөлдөөний нөхцөл байдлын талаарх судалгаанд үндэслэхээр заасан бөгөөд судалгааг дараах холбогдох чиглэлд хийж, уг судалгаанд үндэслэн сонгон шалгаруулалт зарлах шаардлагатай эсэхэд дүгнэлт гаргасан болно.

1. Монгол Улс, Улаанбаатар хот, орон нутгийн хүн ам, өрхийн тоо, нягтралын судалгаа;
2. Өргөн нэвтрүүлгийн үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөлтэй этгээдийн тоо;
3. Өргөн нэвтрүүлгийн үйлчилгээний зах зээлийн багтаамж, хэмжээ, хэрэглэгчийн тоо, өрсөлдөөний нөхцөл байдлын судалгаа;
4. Эрэлт, хэрэгцээ.

Өргөн нэвтрүүлгийн үйлчилгээний тусгай зөвшөөрлийн тоо тогтоох эсэхэд холбогдох дээрх судалгаа, мэдээллээс гадна дараах шалгуурыг харгалзан үзсэн. Үүнд:

1. Радио давтамжийн тусгай зөвшөөрөл шаардлагатай бол радио давтамжийн төлөвлөлт, нөөц;
2. ӨНТХ-ийн 22 дугаар зүйлийн 22.3-т заасан зарчмыг хэрэгжүүлэхтэй холбоотой төрийн өмчийн радио, телевизийн газрын сүлжээний үйлчилгээний сувгийн багтаамж, нөхцөл байдлыг тодорхойлох.

Төрийн өмчийн радио, телевизийн газрын сүлжээний ашиглалтыг төр хариуцах бөгөөд уг сүлжээнд олон нийтийн радио, телевиз болон өргөн нэвтрүүлгийн радио, телевизийг үнэ төлбөргүйгээр холбох, дамжуулах хуулийн зохицуулалт хэрэгждэг ба нээлттэй сонгон шалгаруулалтаар өргөн нэвтрүүлгийн телевизийн үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөл олгох тоо тогтоох нөхцөлд газрын сүлжээний үйлчилгээ эрхлэгчийн сүлжээ, сувгийн багтаамж, техникийн нөхцөл байдлыг харгалзан авч үзэх шаардлагатай байдаг. Иймээс Радио, телевизийн газрын сүлжээ УТҮГ-аас техникийн нөхцөлийг авч үзсэн.



## **Хоёр: Тус Хорооноос 2025 онд сонгон шалгаруулалтаар олгох өргөн нэвтрүүлгийн үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрлийн тоо тогтоох эсэх тухай**

Өргөн нэвтрүүлгийн зохицуулалтын газраас ӨНТХ-ийн 30 дугаар зүйлийн 30.1.9 дэх заалтыг үндэслэн Өргөн нэвтрүүлгийн зах зээлийн багтаамж, хүн амын тоо, нягтрал, эрэлт хэрэгцээ, өрсөлдөөний нөхцөл байдлын талаар хийсэн судалгаа, нээлттэй сонгон шалгаруулалтаар олгох өргөн нэвтрүүлгийн үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрлийн тоо тогтоох эсэх талаар судалгаа, дүгнэлтийг хийж 2025 оны 05 дугаар сарын 08-ны өдрийн Даргын зөвлөлийн хурал, 05 дүгээр сарын 29-ний өдрийн Хорооны хуралдаанд тус тус танилцуулсан.

Хорооны хуралдаанаар ирүүлсэн хүсэлтүүд, зах зээл, өрсөлдөөний нөхцөл, байдал зэрэгт хийсэн судалгаа, дүгнэлтэд үндэслэн 2025 онд нээлттэй сонгон шалгаруулалтаар олгох тусгай зөвшөөрлийн тоог баталлаа. Увс аймагт үйлчилгээ эрхлэх өргөн нэвтрүүлгийн телевизийн үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрлийн тоо 1, Улаанбаатар хотод үйлчилгээ эрхлэх арилжааны телевизийн үйлчилгээ эрхлэх тоо 5 байхаар тогтоосон. Түүнчлэн тухайн орон нутагт радиогүй Баянхонгор, Булган, Говьсүмбэр, Дундговь аймгуудад сонгон шалгаруулалтаар олгох радиогийн үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрлийн тоог аймаг тус бүрт нэг байхаар, телевизгүй Говьсүмбэр, Дундговь аймгуудад арилжааны телевизийн үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрлийн тоог аймаг тус бүрт 1 байхаар тогтлоо.

Дараагийн удаагийн Хорооны хуралдаанаар дээрх тусгай зөвшөөрлийн төрөл, үйлчилгээ эрхлэх байршил тус бүрээр сонгон шалгаруулалтын баримт бичгийг оруулж батлуулан, хуульд заасны дагуу сонгон шалгаруулалтыг зарлан явуулахаар шийдвэрлэсэн.

ХАРИЛЦАА ХОЛБООНЫ ЗОХИЦУУЛАХ ХОРОО